

“МОНОС ХҮНС” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2026 оны 02 сарын 16-ны өдөр

№ 26/01

Улаанбаатар хот

Ногдол ашиг хуваарилах тухай

Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1, 46.2, 46.5 дахь заалт, 47 дугаар зүйлийн 47.1 дэх заалт, 76 дугаар зүйлийн 76.1.12 дахь заалт, “Монос хүнс” ХК-ийн дүрмийн 11 дүгээр зүйлийн 11.5, 11.6 дахь заалт, Санхүүгийн Зохицуулах Хорооны 28 тоот тогтоол, ТУЗ-ийн дэргэдэх Аудит, эрсдэлийн хорооны санал, 2026 оны 02 дугаар сарын 16-ны өдрийн ТУЗ-ийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Монос хүнс” ХК-ийн 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд тусгагдсан цэвэр ашгаас 1,839,826,926 (нэг тэрбум найман зуун гучин есөн сая найман зуун хорин зургаан мянга есөн зуун хорин зургаа) төгрөгийг мөнгөн хэлбэрээр тооцож, нэгж хувьцаанд 4.5 (дөрвөн төгрөг тавин мөнгө) төгрөгийн ногдол ашгийг хуваарилахыг зөвшөөрсүгэй.
2. Ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах өдрийг 2025 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийг бүртгэх бүртгэлийн өдрөөр тогтоосугай.
3. Энэхүү тогтоолын 1 дэх хэсэгт заасан ногдол ашгаас холбогдох хууль тогтоомжид заасан татварыг суутган тооцож, олон нийт буюу 30%-ийн хувьцаа эзэмшигчдийн ногдол ашгийг “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК-аар дамжуулан 2026 оны 04 дүгээр сарын 30-ны өдөрт багтаан хувьцаа эзэмшигчдийн дансанд байршуулах, 70%-ийн хувьцаа эзэмшигчийн ногдол ашгийг 2026 оны 07 дугаар сарын 30-ны өдөрт багтаан шилжүүлэхийг Гүйцэтгэх захирал (А.Отгондарь), Санхүү хариуцсан захирал (Ц.Дэлгэрмаа) нарт үүрэг болгосугай.
4. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавих, ногдол ашиг тараах мэдээллийг зохих журмын дагуу хувьцаа эзэмшигчдэд хүргэхийг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга (Н.Цагаанхүү)-д даалгасугай.

ТУЗ-ИЙН ДАРГА



Х.АНАНД